# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 22 өдөр Дугаар 30 Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 8 дугаар зүйлийн 8.2.1, 8.3 дахь заалт, “Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК-ийн 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 07/16 дугаар албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 230 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.

2. Тус үнэт цаасны компанийн ирүүлсэн саналыг харгалзан гишүүнчлэлийн хөлсийн нийт өр барагдуулах хугацааг 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөр тогтоож, үүргээ хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг хязгаарлах арга хэмжээ шууд авахыг “Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК /С.Гантулга/-д анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ М.БОЛОР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК MONGOLIAN STOCK EXCHANGE ТТА2380 2071096 УЛААНБААТАР ХОТ

000062